



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 12 сарын 14 өдөр

Дугаар A-3Y1

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А-14 дүгээр тушаалаар батлагдсан “Урт хугацаат своп хэлцлийн журам”-ыг энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг баталсугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 730 дугаар тушаалаар батлагдсан “Валютын своп, форвард хэлцлийн ерөнхий гэрээ”-г цуцлах арга хэмжээ авахыг Зах зээлийн газар (Б.Батдаваа)-т даалгасугай.

4. Дээрх өөрчлөлттэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А-139 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийн үнэ цэнийг тооцох заавар”-ыг 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор шинэчлэн боловсруулж, батлуулахыг Эрсдэлийн удирдлагын алба (А.Энхжин)-нд үүрэг болгосугай.

5. Энэ тушаалыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Зах зээлийн газар (Б.Батдаваа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (Э.Анаар), Эрсдэлийн удирдлагын алба (А.Энхжин)-нд тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Баяртсайхан

Н.БАЯРТСАЙХАН

14 2512

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны
12 дугаар сарын 17.-ний өдрийн 13:30
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ВАЛЮТЫН СВОП, ФОРВАРД ХЭЛЦЛИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь арилжааны банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэл бий болгоор Монголбанк төгрөг, ам.долларын своп, форвард хэлцлийг банк /цаашид Банк гэх/-тай хийж, төгрөг болон ам.долларын богино хугацаат эх үүсвэр нийлүүлэх, татах үйл ажиллагаатай холбогдон үүсэх талуудын эрх, үүрэг, бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монголбанк своп, форвард хэлцлийг Монголбанкаас холбогдох хэлцэл байгуулах зөвшөөрөл авсан арилжааны Банктай байгуулна.
- 1.3. Своп, форвард хэлцэл нь Банкны төгрөг, валютын хөрвөх чадварыг хангах, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилготой Төв Банкны мөнгөний бодлогын байнгын бус хэрэгсэл юм.
- 1.4. Төгрөг, юанийн своп хэлцлийн үйл ажиллагаа нь “Төгрөг, юанийн своп хэлцлийн журам”-аар зохицуулагдана.

ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. “**Төгрөгийн своп хэлцэл**” гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк спот ханшаар төгрөг татаж, ам.доллар нийлүүлж хугацааны эцэст Монголбанк форвард ханшаар ам.доллар татаж, төгрөг нийлүүлэх хэлцлийг,
 - 2.1.2. “**Ам.долларын своп хэлцэл**” гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк спот ханшаар ам.доллар татаж, төгрөг нийлүүлж хугацааны эцэст Монголбанк форвард ханшаар төгрөг татаж, ам.доллар нийлүүлэх хэлцлийг,
 - 2.1.3. “**Төгрөгийн форвард хэлцэл**” гэж тодорхой хугацааны дараа форвард ханшаар Монголбанк төгрөг худалдан авч, ам.доллар худалдах хэлцлийг,
 - 2.1.4. “**Ам.долларын форвард хэлцэл**” гэж тодорхой хугацааны дараа форвард ханшаар Монголбанк ам.доллар худалдан авч, төгрөг худалдах хэлцлийг,
 - 2.1.5. “**Спот ханш**” гэж тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкаас зарласан албан ханшийг,
 - 2.1.6. “**Форвард ханш**” гэж спот ханш дээр суурилан тооцсон ирээдүйд төлбөр тооцоо хийгдэх үед ашиглагдах ханшийг.

ГҮРАВ. Своп, форвард хэлцлийн зарчим

- 3.1. Банк нь своп/форвард хэлцэл байгуулах саналаа энэ журмын нэг болон хоёрдугаар хавсралтын дагуу Мягмар, Пүрэв гарагийн 09.30-10.00 цагийн хооронд “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр дамжуулан, Монголбанкинд хүргүүлнэ.
- 3.2. Зах зээлийн газар нь (цаашид ЗЗГ гэх) Банкнаас энэ журмын нэг болон хоёрдугаар хавсралтын дагуу ирүүлсэн своп, форвард хэлцлийн саналыг судалж, биелсэн хэлцлийг

тухайн өдрийн 15:00 цагаас өмнө Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т хүргүүлнэ.

3.3. ТТБГ нь своп, форвард хэлцлийг хэлцэл хийсэн өдөр бүртгэж, төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

3.4. Давагдашгүй хүчин зүйлийн болон цахим арилжааны сүлжээнд эвдрэл гарсны улмаас валютын своп, форвард хэлцэл хийх үйл ажиллагаа тухайн өдрийн 10.00 цагт эхлэх боломжгүй бол дараах үйл ажиллагаа явагдана. Үүнд:

3.4.1. Монголбанк хэлцэл хийх хугацааг сунгаж болно. Ингэхдээ хэлцэл хийх үйл ажиллагаа явагдахаас 10 минутын өмнө Банкуудад “Гадаад валютын цахим арилжааны систем”-ээр дамжуулах эсвэл утсаар мэдэгдэнэ.

3.4.2. Цахим арилжааны сүлжээнд гарсан эвдрэлийг засах боломжгүй тохиолдолд “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ын нэг, хоёрдугаар хавсралтын дагуу Банкнаас своп, форвард хэлцэл хийх саналыг баталгаат гарын үсэг, тамга тэмдгийг шалган бичгээр авна. Монголбанкны эдийн засагч нь Банкны саналын битүүмж, лацыг шалган, баримт үйлдэж эсвэл факсаар хүлээн авна.

3.4.3. Монголбанк хэлцлийн хугацааны эцэст Банкнаас төлбөрийн даалгавар ирсэн эсэхээс үл хамаарч ам.доллар, төгрөгийн буцах гүйлгээг хийнэ.

ДӨРӨВ. Своп, форвард хэлцлийн үидсэн нохцол

4.1. Монголбанк Банктай энэ журмын гуравдугаар хавсралтад заасан нөхцөлөөр своп, форвард хэлцэл байгуулна.

4.2. Банкны Монголбанктай байгуулсан идэвхтэй своп хэлцлийн нийт хэмжээ нь тухайн Банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс хэтрэхгүй байна.

4.3. Тухайн форвард хэлцлийг хийснээр Банкны гадаад валютын эрсдэлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаж байхаар хэлцлийн хэмжээг хязгаарлана.

4.4. Энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасны дагуу своп/форвард хэлцлийн форвард ханшийг тооцно.

4.5. Монголбанк форвард хэлцлийн дагуу Банкны хугацааны эцэст төлбөр хийх валютын мөнгөн дүнгийн 10 хувьтай тэнцүү хэмжээгээр Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдлийг царцаана.

4.6. Своп, форвард хэлцлийн төгрөгийн эх үүсвэрт ACT/365, ам.долларын эх үүсвэрт ACT/360 хоногийн суурь ашиглана.

4.7. Форвард ханшийг нэгжийн орны таслалаас хойш 4 оронтойгоор тооцно.

4.8. Төгрөгөөр илэрхийлсэн мөнгөн дүн нь төгрөг, мөнгө гэсэн бүтэцтэй байна.

4.9. Хэлцлийн хугацааны эцэст амралтын өдөр, нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиохор бол уг өдрийн дараагийн ажлын өдөр төлбөр тооцоо хийгдэхээр Банк своп, форвард хэлцлийн саналаа өгнө.

ТАВ. Талуудын эрх

5.1. Монголбанк дор дурдсан эрхтэй:

5.1.1. Своп, форвард хэлцэл хийх шийдвэр гаргахад шаардагдах санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийг Банкнаас гаргуулан авах,

5.1.2. Монголбанк төгрөг, гадаад валютын захын тухайн үеийн болон хүлээгдэж буй нөхцөл байдал, Банкны төлбөр гүйцэтгэх чадвар, бусад хүчин зүйлсийг харгалзан

үзээд своп, форвард хэлцэл хийх саналыг хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр биелүүлэхээс татгалзах, татгалзсан шалтгаанаа тайлбарлахгүй байх.

5.2. Банк дор дурдсан эрхтэй:

5.2.1. Своп, форвард хэлцлийн санал биелсэн эсэх мэдээллийг тухайн өдрийн 15:00 цагаас өмнө Монголбанкнаас авах;

ЗУРГАА. Талуудын үүрэг

6.1. Монголбанк дор дурдсан үүрэгтэй:

6.1.1. Монголбанк нь Банк тус бүртэй байгуулсан своп, форвард хэлцэл, энэ журмын 5.1.1-д заасан мэдээллийн нууцлалыг хангах,

6.1.2. Энэ журамд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 2 өдрийн дотор Банкинд мэдэгдэх,

6.1.3. Своп, форвард хэлцлийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх.

6.2. Банк дор дурдсан үүрэгтэй:

6.2.1. Своп хэлцлийн саналын дүн нь тухайн өдөр хугацаа нь дуусч буй Монголбанктай байгуулсан тухайн валютаарх своп хэлцлийн үлдэгдэл, Монголбанк дахь харилцах данс дахь үлдэгдлийн нийлбэрээс ихгүй байхаар саналаа ирүүлэх,

6.2.2. Своп, форвард хэлцлийн хугацааны эцэст Банк нь хүрэлцэхүйц хэмжээний үлдэгдлийг Монголбанк дахь харилцах дансанд байршуулах,

6.2.3. Своп, форвард хэлцлийн саналыг буцаахгүй, цуцлахгүй байх,

6.2.4. Монголбанкнаас шийдвэр гаргахад шаардагдах санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийг Монголбанкны ЗЗГ-т заасан хугацааны дотор үнэн, зөв ирүүлэх,

6.2.5. Своп, форвард хэлцлийн саналыг бичгээр ирүүлэх тохиолдолд Банкны зөвхөн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байх,

6.2.6. Банкны эрх бүхий ажилтны гарын үсгийн баталгааны өөрчлөлтийн талаар Монголбанкинд ажлын 2 өдрийн дотор дараагийн хэлцлийн өдрөөс өмнө бичгээр мэдэгдэх,

ДОЛОО. Хэлцлийн үүргийг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ

7.1. Банк нь энэ журмын 6.2.1 дэх заалтыг зөрчсөн тохиолдолд тус саналыг Монголбанк цуцална. Энэ үйлдэл хоёр удаа давтагдсан тохиолдолд Банкинд сануулга хүргүүлнэ.

7.2. Банк нь ам.долларын своп, төгрөгийн форвард хэлцлийн хугацааны эцэст төлбөр тооцоог гүйцэтгэхэд Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд Монголбанк ам.долларын гүйлгээг хийхгүй бөгөөд төлбөрийн үлдэгдлийг Монголбанк дараах байдлаар төлүүлнэ:

7.2.1. Монголбанк дахь ам.долларын харилцах данснаас тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкны зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төлүүлнэ.

7.2.2. Монголбанк дахь ам.долларын харилцах дансны үлдэгдэл Банкны төлох төгрөгийн дүнд хүрэлцэхгүй бол бусад гадаад валютын харилцах дансны үлдэгдэл, төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдэл, эзэмшиж буй ТБҮЦ, ЗГҮЦ-наас суутгаж, төлүүлнэ.

7.2.3. Энэ журмын 7.2.1, 7.2.2-т заасан арга хэмжээг авсны дараа төлбөр барагдаагүй тохиолдолд Банкийг хүрэлцэхүйц төгрөг харилцахдаа байршуулах хүртэл хугацаанд

алдангийг Монголбанкны овернайт репо санхүүжилтийн хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж тооцно.

7.3. Банк нь төгрөгийн своп, ам.долларын форвард хэлцлийн хугацааны эцэст төлбөр тооцоог гүйцэтгэхэд Монголбанк дахь ам.долларын харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд Монголбанк төгрөгийн гүйлгээг хийхгүй бөгөөд төлбөрийн үлдэгдлийг Монголбанк дараах байдлаар төлүүлнэ:

7.3.1. Монголбанк дахь бусад валютын харилцах данснаас тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкны зарласан албан ханшаар ам.долларт хөрвүүлж, төлүүлнэ.

7.3.2. Монголбанк дахь бусад валютын харилцах дансны үлдэгдэл Банкны төлөх ам.долларын дүнд хүрэлцэхгүй бол төгрөгийн харилцах дансны үлдэгдэл, валют, төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл, эзэмшиж буй ТБҮЦ, ЗГҮЦ-наас суутгаж, төлүүлнэ.

7.3.3. Энэ журмын 7.3.1, 7.3.2-т заасан арга хэмжээг авсны дараа төлбөр барагдаагүй тохиолдолд Банкийг хүрэлцэхүйц ам.доллар харилцахдаа байршуулах хүртэл хугацаанд алдангийг хэлцлийн ам.долларын эх үүсвэрт тооцсон хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж тооцно.

7.4. Банк төлбөрийг ЗГҮЦ болон ТБҮЦ-аар барагдуулах бол зах зээлийн үнийг Монголбанкны холбогдох эрх зүйн актад заасны дагуу хямдруулж тооцно.

7.5. Энэ журмын 7.2.3, 7.3.3-т заасны дагуу алданги тооцож эхэлснээс хойш Банк ажлын 5 хоногт төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд Монголбанк хэлцлийн форвард гүйлгээг цуцалж, 7.2, 7.3-т заасан алдангиас бусад эх үүсвэрийг Банкны төгрөгийн харилцах дансанд буцаах бөгөөд хэлцлийн төгрөгийн дүнгийн 0.5 хувьтай тэнцүү мөнгөн торгуулийг ногдуулна.

7.6. Энэ журмын 7.1-д заасан сануулга 2 удаа, 7.2, 7.3-т заасан арга хэмжээ 3 удаа, 7.5-д заасан арга хэмжээ 2 удаа тус тус давтагдсан тохиолдолд Монголбанкнаас Банкны своп, форвард хэлцэл хийх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ооо

СВОП ХЭЛЦЭЛ

Хэлцэл хийсэн огноо:

.... оны сарын өдөр

Хэлцлийн төрөл:

Төгрөгийн своп/Ам.долларын своп

1. Банкны нэр :

.....

2. Хугацаа :

..... хоног

3. Эхний гүйлгээ :

..... Банкны

3.1 Худалдан авах валют

.....

3.2 Хэмжээ

тоогоор (үсгээр)

3.3 Ханш

.....

3.4 Огноо

... оны ... сарын ... өдөр

4. Форвард гүйлгээ :

..... Банкны

4.1 Худалдах валют:

.....

4.2 Хэмжээ

тоогоор (үсгээр)

4.3 Ханш

.....

4.4 Огноо

... оны ... сарын ... өдөр

5. Төгрөгийн эх үүсвэрийн хүү

.....

6. Ам.долларын эх үүсвэрийн хүү

.....

МОНГОЛБАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТАМГА:

ТАМГА:

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ:

ФОРВАРД ХЭЛЦЭЛ

Хэлцэл хийсэн огноо: оны сарын өдөр

..... Банкны

1. Худалдан авах валютын төрөл:
2. Хэмжээ: тоогоор (үсгээр)
3. Худалдах валютын төрөл:
4. Хэмжээ: тоогоор (үсгээр)
5. Валютын хөрвүүлэгт ашигласан валютын ханш: Өмнөх өдрийн Монголбанкны хаалтын ханш
6. Форвард ханш:
7. Төгрөгийн эх үүсвэрийн хүү
8. Ам.долларын эх үүсвэрийн хүү
9. Хугацаа:
10. Төлбөр хийх огноо: оны ... сарын ... өдөр

МОНГОЛБАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ: БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТАМГА:

ТАМГА:

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ:

СВОП, ФОРВАРД ХЭЛЦЛИЙН НӨХЦӨЛ

№	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хугацаа	1, 7 хоног, 1 сар, 3 сар
2	Хэмжээ	Дээд: 50,000,000.0 ам.доллар Доод: 1,000,000.0 ам.доллар
3	Эхний гүйлгээ	Своп хэлцэл: Тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкинаас зарласан албан ханшаар хөрвүүлж, эх үүсвэр солилцно. Форвард хэлцэл: Байхгүй
4	Форвард гүйлгээ	Своп, форвард хэлцэл: Эхний гүйлгээгээр солилцсон эх үүсвэрийг форвард ханшаар төгрөгт хөрвүүлж, буцаан солилцно.
5	Төгрөгийн эх үүсвэрийн хүү	Төгрөгийн своп, ам.долларын форвард: Монголбанкины овернайт хадгаламжийн хүү Ам.долларын своп, төгрөгийн форвард: Монголбанкины овернайт репо санхүүжилтийн хүү
6	Ам.долларын эх үүсвэрийн хүү	Төгрөгийн своп, ам.долларын форвард: Харгалзах хугацааны Лондонгийн Банк хоорондын захын хүү (LIBOR) + Хамгийн сүүлд зарлагдсан банкуудын валютын харилцахын жигнэсэн дундаж хүү Ам.долларын своп, төгрөгийн форвард: Харгалзах хугацааны Лондонгийн Банк хоорондын захын хүү (LIBOR)

Эх сурвалж: Блүмберг, Монголбанкины сарын буллетин

ФОРВАРД ХАНШИЙН ТООЦООЛОЛ

Форвард ханшийг доорх томъёогоор тооцно.

$$F_{bid}(MNT\ swap, USD\ forward) = S_{rate} * \frac{1 + I_{mnt_bid} * t/365}{1 + I_{usd_ask} * t/360}$$

$$F_{ask}(USD\ swap, MNT\ forward) = S_{rate} * \frac{1 + I_{mnt_ask} * t/365}{1 + I_{usd_bid} * t/360}$$

Үзүүлэлт	Тайлбар	
I_x	Эх үүсвэрт харгалзах хүү (100-д хувааснаар)	
I_{mnt_bid}	Монголбанкны своп хэлцлийн эхний гүйлгээгээр төгрөгийн эх үүсвэр худалдан авах, форвард хэлцлээр төгрөг худалдах хүү	Төв Банкны овернайт хадгаламжийн хүү
I_{mnt_ask}	Монголбанкны своп хэлцлийн эхний гүйлгээгээр төгрөгийн эх үүсвэр худадах, форвард хэлцлээр төгрөг худалдан авах хүү	Төв Банкны овернайт репо санхүүжилтийн хүү
I_{usd_bid}	Монголбанкны своп хэлцлийн эхний гүйлгээгээр ам.долларын эх үүсвэр худалдан авах, форвард хэлцлээр ам.доллар худалдах хүү	Харгалзах хугацааны Лондонгийн Банк хоорондын захын хүү (LIBOR)
I_{usd_ask}	Монголбанкны своп хэлцлийн эхний гүйлгээгээр ам.долларын эх үүсвэр худалдах, форвард хэлцлээр ам.доллар худалдан авах хүү	Харгалзах хугацааны Лондонгийн Банк хоорондын захын хүү (LIBOR) + Хамгийн сүүлд зарлагдсан банкуудын ам.долларын харилцахын жигнэсэн дундаж хүү <i>Эх сурвалж: Блуумберг, Монголбанкны сарын буллетин</i>
t	Хэлцлийн хугацаа өдрөөр	
F_{bid}	Монголбанкны форвард гүйлгээгээр валют худалдаж авах форвард ханш (төгрөгийн своп, ам.долларын форвард)	
F_{ask}	Монголбанкны форвард гүйлгээгээр валют худалдах форвард ханш (ам.долларын своп, төгрөгийн форвард)	
S_{rate}	Тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш	